

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй зохицон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, судалгааг тасралтгүй явуулах, шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээ, мэдээллээр хүн, хуулийн этгээд (цаашид “хэрэглэгч” гэх)-ийг хангах, эрт сэрэмжлүүлэх тогтолцоог бэхжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж

2.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Агаарын тухай хууль, Усны тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Газрын тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль, энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулиар ус, цаг уур, орчин, уур амьсгалын хяналт шинжилгээ, судалгаа, ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ, бодит болон урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг, мэдээллийн сан, архив, мэдээллийн үйлчилгээ, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дараах утгаар ойлгоно.

4.1.1. “ус цаг уур” гэж гадаргын ус судлал болон цаг уур судлалын ухааныг хамтад нь;

- 4.1.2. “цаг агаар” гэж агаар мандлын төлөв байдал, агаар мандалд ажиглагддаг байгалийн үзэгдлийн цогцыг;
- 4.1.3 “цаг уур” гэж дэлхийн агаар мандлыг судалдаг шинжлэх ухааны салбарыг;
- 4.1.4. “ус судлал” гэж усан орчны хувьсал, өөрчлөлтийг судалдаг ухааныг;
- 4.1.5. “ус цаг уур, орчны хяналт шинжилгээ” гэж хийн мандал, усан мандал, шим мандлын байгалийн төлөв байдал, хувьсал өөрчлөлтийн үйл явц, үзэгдэл, байгаль орчны төлөв байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийг нэгдмэл арга зүй, хөтөлбөрөөр ажиглаж, хэмжиж, дүн шинжилгээ хийж зохих мэдээлэл, зөвлөмж, шийдэл гаргах үйл ажиллагааг;
- 4.1.6. “уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээ” гэж уур амьсгалын өөрчлөлтийг урт хугацаанд ажиглах, үнэлэх, дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг;
- 4.1.7. “хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалт” гэж мал аж ахуй, таримал ургамал, бэлчээрийн ургамал, хөрсний төлөв байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийг ажиглах, хэмжих үйл ажиллагааг;
- 4.1.8. “бодит мэдээ” гэж тухайн цаг хугацаа, байршилд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хэмжилт, ажиглалтаар тогтоогдсон агаар мандал, ус, хөрс болон хүрээлэн буй орчны төлөв байдлын анхан шатны мэдээ, мэдээллийг;
- 4.1.9. “урьдчилсан мэдээ” гэж ус цаг уур, орчны төлөв байдал, хувьсал, өөрчлөлтийн үйл явцыг хэдэн цаг, хоног, сар, улирлын өмнө шинжлэх ухааны үндэслэлтэй урьдчилан тооцоолж гаргасан мэдээллийг;
- 4.1.10. “сэрэмжлүүлэг” гэж ус цаг уурын үзэгдэл, орчны бохирдол нь хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд эрсдэл учруулж болзошгүй тухай урьдчилсан мэдээг;
- 4.1.11. “нийтийн хэрэгцээний мэдээ” гэж олон нийтэд зориулан нийтэд нээлттэйгээр түгээдэг ус цаг уур, орчны мэдээллийг;
- 4.1.12. “тусгай хэрэгцээний мэдээ” гэж тодорхой хэрэглэгчийн захиалгаар боловсруулан гаргасан ус цаг уур, орчны мэдээллийг;
- 4.1.13. “аюултай үзэгдэл” хүний амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд хохирол учруулж, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх ус цаг агаарын үзэгдлийг;
- 4.1.14. “онц аюултай үзэгдэл” гэж олон хүний амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд ихээхэн хохирол учруулж, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагааг тодорхой хугацаанд зогсоох хэмжээний сөрөг нөлөө үзүүлэх ус цаг агаарын үзэгдлийг;

- 4.1.15. "анхааруулах мэдээ" гэж Ус, цаг агаар, орчны байдал эрс өөрчлөгдөх, цаашид аюултай үзэгдлийн хэмжээнд хүрч болзошгүй нөхцөл үүссэн тухай сэрэмжлүүлгийг,
- 4.1.16 "сэрэмжлүүлэх мэдээ" гэж Ус, цаг агаар, орчны аюултай үзэгдэл ажиглагдах нөхцөл бүрдсэн тухай сэрэмжлүүлгийг,
- 4.1.17. "урьдчилан сэргийлэх мэдээ" гэж Ус, цаг агаар, орчны онц аюултай үзэгдэл ажиглагдах нөхцөл бүрдсэн тухай сэрэмжлүүлгийг,
- 4.1.18 "уур амьсгал" гэж тодорхой газар нутгийн цаг агаарын олон жилийн дундаж, хэлбэлзэл, давтагдах хэв шинжээр илэрхийлэгдэх төлөв байдлыг;
- 4.1.19. "урьдчилсан төлөв" гэж сар болон түүнээс дээш хугацааны уур амьсгалын төлөв байдлыг урьдчилан тодорхойлж гаргасан мэдээллийг;
- 4.1.20. "цаг агаарт зориудаар нөлөөлөх" гэж шинжлэх ухаан, технологийн шийдлээр агаар мандлын процессод зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг;
- 4.1.21. "ажиглалтын станц" гэж ажиглалт, хэмжилт хийх зориулалтай тоног төхөөрөмж, байгууламж, талбайн цогц бүхий ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн байгууллагын нэгжийг;
- 4.1.22 "шинжилгээний талбай" гэж ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийх зориулалтаар сонгон авч төхөөрөмжилсэн, хашаалсан болон өөр бусад байдлаар тэмдэглэж, заагласан орон зайг;
- 4.1.23 "уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хувилбар" гэж уур амьсгал хэрхэн өөрчлөгдөх боломжит төлөв, хандлагыг шинжлэх ухааны аргаар тооцоолсон урьдчилсан төсөөллийг;
- 4.1.24. "уур амьсгалын стандарт норм" гэж цаг уурын улсын сүлжээний станцын хэмжилтийн мэдээлэлд тулгуурлан тооцсон цаг уурын үзүүлэлтүүдийн 30 жилийн дундаж утгыг;
- 4.1.25. "Нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ" гэж аюул, өртөмхий байдал, эмзэг байдлын мэдээлэлд үндэслэн ус цаг уур, орчны аюулын нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан төсөөлж, авах арга хэмжээний зөвлөмжийг агуулсан мэдээг;
- 4.1.26. "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний алба" гэж ус цаг уур, уур амьсгал, ус судлал, орчны төлөв байдал, байгал, цаг уурын үзэгдлийг ажиглах, хэмжих, хянах, шинжлэх, судлах, мэдээлэл боловсруулах, урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага, түүний харьяа мэргэжлийн байгууллагуудыг;

5 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний зарчим

5.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтлана:

- 5.1.1. тасралтгүй, тогтвортой байх;
- 5.1.2. шинжлэх ухааны үндэслэлтэй байх;
- 5.1.3. хэмжлийн нэгдмэл байдлыг хангасан байх;
- 5.1.4. газар нутгийн өвөрмөгц байдлыг илэрхийлж чадахуйц байх;
- 5.1.5. үнэн зөв, ил тод, хүртээмжтэй байх;
- 5.1.6. мэдээлэл солилцооны уялдаа, нийцлийг хангасан байх;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ УЛСЫН СҮЛЖЭЭ, ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГА

6 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ

6.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ /цаашид “улсын сүлжээ” гэх/ нь ус, цаг уур, орчны төлөв байдлыг ажиглах, хэмжих, мэдээллээр хангах, уур амьсгалын өөрчлөлтийг үнэлэх, дүн шинжилгээ хийх зорилго бүхий байгууллага, ажиглалтын станц, лаборатори, шинжилгээний талбайгаас бүрдэнэ.

6.2. Улсын сүлжээг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэгдсэн удирдлага, нэгдмэл арга зүйгээр хангана.

6.3. Улсын сүлжээний үйл ажиллагаа, багаж, тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

6.4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, уур амьсгалын судалгаа, үйлчилгээнд инновац, дэвшилтэт технологи нэвтрүүлэх болон өндөр ур чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

7 дугаар зүйл. Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөө

7.1. Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

7.2. Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгана:

- 7.2.1. Ус, цаг агаар, орчны аюултай болон онц аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авахад шаардлагатай ус цаг уур, орчны мэдээллийн хэрэгцээ;
- 7.2.2. Уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээ, үнэлгээ;
- 7.2.3. Улсын сүлжээний ажиглалтын станцын байршил, нягтрал, ангилал, зэрэглэл, төлөвлөлтийн зураг, үйл ажиллагааны хөтөлбөр;

7.2.4 Төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөөц, арга хэмжээ, үе шат

7.2.5. Өмнөх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ;

7.3. Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөг 10 жилийн хугацаагаар батална.

8 дугаар зүйл. Улсын сүлжээний ажиглалтын станц

8.1. Улсын сүлжээний ажиглалтын станц нь үйл ажиллагааны хөтөлбөртэй байна. Ижил төрлийн станц нэг хөтөлбөрөөр ажиллана.

8.2. Улсын сүлжээний ажиглалтын станц нь дараах төрөлтэй байна:

8.2.1. цаг уурын

8.2.2. ус судлалын;

8.2.3. орчны хяналт шинжилгээний

8.2.4 хөдөө аж ахуйн цаг уурын;

8.2.5. дээд агаар мандлын;

8.2.6 цаг уурын радарын;

8.2.7 мал аж ахуйн цаг уурын;

8.2.8 нарны цацраг судлалын;

8.2.9. хүлэмжийн хийн;

8.2.10. тусгай зориулалтын бусад;

8.3. Улсын сүлжээний ажиглалтын станцыг ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр байгуулна.

8.4. Улсын сүлжээнд хамаарах ажиглалтын станц төрийн өмч байна.

8.5. Улсын сүлжээнд хамаарах станцыг доор дурдсанаас бусад тохиолдолд нүүлгэн шилжүүлэхийг хориглоно:

8.5.1. гамшгийн улмаас ашиглах боломжгүй болсон;

8.5.2. батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлын шаардлага үүссэн;

8.5.3. байгалийн нөхцөлөөс шалтгаалан ажиглалт, хэмжилтийн шаардлага хангах боломжгүй болсон.

8.5.4 ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажиглалт, хэмжилтийн мэдээлэл, өгөгдөл нь орчныг төлөөлөх чадваргүй болсон.

8.6. Ажиглалтын станц нь ажиглалт хийх техникийн нөхцөлийг хангахгүй болсон, эсхүл нүүлгэн шилжүүлэх боломжгүй болсон тохиолдолд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр үйл ажиллагааг зогсооно.

8.7. Ажиглалтын станцын байршлыг өөрчлөх тохиолдолд шинэ болон хуучин байрлалд 3-аас доошгүй жил зэрэгцсэн хэмжилт хийж, нийцлийг үнэлсний үндсэн дээр шийдвэрлэнэ.

8.8. Улсын сүлжээний станц нь төрөл, хөтөлбөр, хүний нөөц, хэмжих хэрэгслийн чадамж зэргээс хамааран гурван зэрэглэлтэй байх бөгөөд зэрэглэлийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

9 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ

9.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээг олон улсын болон үндэсний стандарт, арга зүй, техникийн заавар, журмыг баримтлан тасралтгүй, үнэн зөв явуулна.

9.2. Хяналт шинжилгээний үр дүн нь тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, уур амьсгалын төлөв байдлыг бодитой, үнэн зөв илэрхийлсэн байна.

9.3. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээг дэвшилтэт техник, технологи, инновацид тулгуурлан явуулна.

9.4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд шинэ техник, технологи, автомат багаж, хиймэл оюун ухаанд суурилсан арга, аргачлалыг нэвтрүүлэх, хүний оролцооны алдааг бууруулах, өгөгдлийн чанар, хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн явуулна.

9.5. Ус цаг уур, орчны хяналт, шинжилгээний хэмжилт, ажиглалтад ашиглах багаж, төхөөрөмж нь баталгаажсан, хэмжил зүйн шаардлага хангасан байна.

9.6. Баталгаажуулаагүй хэмжих хэрэгслээр хийсэн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээг албан ёсны мэдээлэлд ашиглахыг хориглоно.

9.7. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд агаар мандал, гадаргын ус, хөрсний чийг, дулаан, бэлчээр, ургамал, ган, зуд, цөлжилт, хөдөө аж ахуйн цаг уур болон орчны төлөв байдлыг илэрхийлэх бусад үзүүлэлтийн ажиглалт, хэмжилт, шинжилгээ, судалгаа, тайлан, дүгнэлт хамаарна.

9.8. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний болон аюулт үзэгдэл, гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийн хангалт, ашиглалттай холбоотой хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилтэд улсын байцаагч хяналт тавина.

10 дугаар зүйл. Шинжилгээний талбай

10.1. Ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийх шинжилгээний талбай нь тусгайлан сонгон авч, төхөөрөмжилсөн, заагласан газар байна.

10.2. Шинжилгээний талбайн орчноо төлөөлөх чадварыг хамгаалах зорилгоор уг талбайгаас гадагш 100 метрийн дотор хамгаалалтын бүс тогтооно.

10.3. Шинжилгээний талбай, хамгаалалтын бүс нь улсын тусгай хэрэгцээний газарт хамаарна.

10.4. Шинжилгээний талбай нь олон улсын болон үндэсний стандарт, технологийн зааварыг хангасан байна.

10.5. Шинжилгээний талбайд зориулалтын бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

10.6. Хамгаалалтын бүсэд ажиглалт, хэмжилтийн үр дүнд сөргөөр нөлөөлөх барилга байгууламж барих, үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

10.7. Эзэмшигч талтай харилцан тохирсны үндсэн дээр төрийн болон хувийн эзэмшлийн газар, барилга байгууламжийн орчинд ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт, судалгааг хийж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ БОДИТ БОЛОН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ, СЭРЭМЖЛҮҮЛЭГ

11 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны бодит болон урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийн ангилал, төрөл, хугацаа, үнэлгээ

11.1. Ус цаг уур, орчны бодит болон урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг нь дараах ангилалтай байна:

11.1.1. нийтийн хэрэгцээний мэдээ;

11.1.2. тусгай хэрэгцээний мэдээ.

11.2. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ дараах төрөлтэй байна:

11.2.1. ус, цаг агаар, орчны урьдчилсан мэдээ;

11.2.2. ус, цаг агаар, уур амьсгал, орчны урьдчилсан төлөв;

11.2.3 хөдөө аж ахуйн цаг уурын урьдчилсан мэдээ;

11.2.4. Ус цаг уур, орчны сэрэмжлүүлэг нь дараах төрөлтэй байна:

11.2.4.1. анхааруулах мэдээ;

11.2.4.2. сэрэмжлүүлэх мэдээ;

11.2.4.3. урьдчилан сэргийлэх мэдээ.

11.3. Энэ хуулийн 11.2.4.1-т заасан анхааруулах мэдээнд хамаарах ус цаг уурын үзэгдлийн жагсаалтыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

11.4. Энэ хуулийн 11.2.4.2, 11.2.4.3-т заасан мэдээнд хамаарах ус цаг уурын үзэгдлийн жагсаалт, гэнэтийн аюул, үйлдвэрлэлийн ослын үед нийтэд мэдээлэх орчны ноцтой бохирдлын сэрэмжлүүлэх мэдээний жагсаалтыг Засгийн газар батална.

11.5. Ус цаг уурын гаралтай үзэгдлийг хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хөдөө аж ахуйн болон эдийн засгийн бусад салбарт учруулж болзошгүй хор хөнөөл, хамрах цар хүрээгээр нь аюултай болон онц аюултай үзэгдэл гэж ангилна.

11.6. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэгийн хугацаа:

11.7.1. хэт богино хугацаа /1-3 цаг/;

11.7.2. богино хугацаа /1-5 хоног/;

11.7.3. дунд хугацаа /5-10 хоног/;

11.7.4. урт хугацаа /1-6 сар/;

11.7.5. бусад хугацаа.

11.8. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг нь нийгэм, эдийн засаг, хүн ам, эд хөрөнгөд үзүүлж болзошгүй нөлөөлөл болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмжийг тусгасан байж болно.

12 дугаар зүйл. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг гаргах

12.1. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон түүний харьяа байгууллага гаргана.

12.2. Урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг гаргах үйл ажиллагаанд дараах ажиллагаа хамаарна:

12.2.1. мэдээ, мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх;

12.2.2. урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг боловсруулах;

12.2.3. хэрэглэгчийг мэдээллээр хангах;

12.2.4. урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийн чанарын үнэлгээ хийх;

12.3. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Үндэсний олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, харилцаа холбооны байгууллага, иргэдэд хүргэнэ

12.4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас бусад эх сурвалжаас гаргасан урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг нь олон нийтэд **хүрснээр** иргэн, аж ахуйн нэгж, нийгэм, эдийн засагт үүссэн хохирол, зөрчлийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллага хариуцахгүй.

13 дугаар зүйл. Ус цаг уур, орчны мэдээ, мэдээллийг дамжуулах

13.1. Улсын сүлжээний ажиглалтын станцын мэдээ, мэдээллийг тогтоосон хяналтын хугацаанд дамжуулна.

13.2 Ус цаг уур, орчны мэдээ, мэдээллийг олон улсын цаг уурын харилцаа холбооны сүлжээнд дамжуулах, уг сүлжээнээс Монгол Улсад шаардлагатай мэдээ, мэдээллийг хүлээн авахад дотоодын болон олон улсын холбооны сувгийг ашиглана. Уг сувгаар газар хөдлөлт, химийн болон цөмийн осол, иргэний нисэхийн цаг уурын мэдээ зэрэг шуурхай мэдээ, мэдээллийг дамжуулж болно.

13.3. Ус цаг агаар, орчны аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг харилцаа холбооны бүх төрлийн хэрэгслээр өмчийн хэлбэр харгалзахгүйгээр шуурхай дамжуулна.

13.4. Иргэд хүн ам, байгаль орчинд ноцтой нөлөөлөх аюулт үзэгдэл, гамшиг тохиолдсон буюу тохиолдох нөхцөл бүрдсэн тухай ус цаг уур, орчны хяналт шинжилгээний аль ч байгууллагад яаралтай мэдээлнэ. Шаардлагатай тохиолдолд холбогдох зардлыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон үнэлгээний дагуу иргэнд нөхөн олгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН, АРХИВ

14 дүгээр зүйл. Ус, цаг агаар, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн нэгдсэн сан

14.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний алба нь байгаль орчны улсын мэдээллийн сантай уялдсан ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээ, мэдээллийн нэгдсэн сантай байна. Уг сан нь төрийн өмч байна.

14.2. Нэгдсэн сан нь дараах ус, цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллээс бүрдэнэ.

14.2.1. Ус, цаг агаар, уур амьсгал, орчны ажиглалт, хэмжилтиймэдээ, баримт;

14.2.2. Гадаад улс, олон улсын байгууллагаас хүлээн авсан мэдээ, баримт;

14.2.3. Хиймэл дагуулын мэдээ, ой, хээрийн түймэр, ургамалжилт, цасан бүрхүүл, хөрсний сэдэвчилсэн зураглал;

14.2.4. Ус цаг уур, орчны бодит болон урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг, төлөв байдлын тойм;

14.2.5. Ажиглалтын станц, хэмжих хэрэгслийн техникийн бүртгэл;

14.2.6. Ус цаг уур, орчны шинжлэх ухааны судалгаа, төсөл хөтөлбөрийн үр дүн, тайлан;

14.2.7. Агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр дүн, тайлан;

14.2.8. Техникийн заавар, үйл ажиллагааны журам;

14.2.9. Байгаль орчны төлөв байдлын тайлан;

14.2.10. Озон, мал аж ахуй, газар бүрхэвчийн салбарын хүлэмжийн хийн ялгаралт, озон задалдаг бодисуудын тоо бүртгэл;

14.2.11. Хөрс бэлчээр, ой, хүлэрт намаг, газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлттэй холбогдох хүлэмжийн хийн шингээлт;

14.3. Нэгдсэн сангийн үйл ажиллагаа, бүрдүүлэлт, ашиглах асуудлыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

14.4. Нэгдсэн сангийн өгөгдөл, мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмж, кибер аюулгүй байдлыг хангах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.

15 дугаар зүйл. Мэдээллийн нэгдсэн сангийн ашиглалт, хэрэглээ, төрөлжсөн архив

15.1. Хэрэглэгч нэгдсэн сан, архивын мэдээллийг энэ хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу ашиглаж болно.

15.2. Хэрэглэгчийн ашиглаж буй ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн эх сурвалж нь тодорхой байх бөгөөд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталгаажуулсан байна.

15.3. Нэгдсэн сан, архивын баримтаас лавлагаа, мэдээлэл авахад үйлчилгээний хөлс төлнө. Үйлчилгээний хөлсийг хуулиар эрх олгосон байгууллага батална.

15.4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээ, мэдээллийн архив нь төрөлжсөн архив байна.

15.5. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний төрөлжсөн архив нь ус цаг уур, орчны хяналтын чиглэлээр хийгдсэн ажиглалт, хэмжилт, шинжилгээ судалгааны эх болон боловсруулсан мэдээ баримтыг бүрдүүлэх, хадгалж хамгаалах, зүй зохистой ашиглах байнгын үйл ажиллагааг явуулна.

15.6. Ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийг байнга хадгалж, архивлана.

15.7. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний төрөлжсөн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, хөгжүүлэлт хийж болно.

15.8. Төрийн бүх шатны байгууллага нь бодлого боловсруулах, төлөвлөх, шийдвэр гаргах, зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчны болон бусад үнэлгээ хийхэд энэ хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээ, мэдээллийг үндсэн эх сурвалжийн нэг болгон ашиглана.

ТАВДУГААР БҮЛЭГ

ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ БАЙДАЛД ЗОРИУДААР НӨЛӨӨЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

16 дугаар зүйл. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа

16.1. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг дараах зорилгоор явуулж болно.

16.1.1. Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;

16.1.2. Аадар бороо, мөндөр зэрэг хур тунадасны эрчмийг бууруулах,

16.1.3. Манан сарниулах;

16.2. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих, үйл ажиллагааны аюулгүй байдлыг

хангах, шинэ техник технологи нэвтрүүлэх, үр дүнг тооцох, үр дүнгийн талаар холбогдох байгууллагад тайлагнах ажлыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

16.3. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгэм, эдийн засаг болон улсын батлан хамгаалах үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байна.

16.4. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх техник хэрэгсэл, тоног **төхөөрөмж**, урвалж бодисыг зориулалтын бусаар ашиглахыг хориглоно.

16.5. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг иргэний нисэхийн болон холбогдох бусад байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулна.

16.6. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хэрэглэгчтэй гэрээ байгуулан цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг явуулж болно.

16.7. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулах тохиолдолд тухайн орон нутгийн захиргааны байгууллагад мэдээлнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

17 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

17.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээтэй холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

17.1.2. Энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг баталж, зарцуулалтад хяналт тавих;

17.1.3. Хуульд заасан бусад бүрэн эрх.

18 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

18.1. Засгийн газар ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1. Ус цаг уур, орчны мэдээлэл, уур амьсгалын нөөцийг нийгэм, эдийн засгийн хөгжилд бүрэн ашиглах;

18.1.2. Ус цаг уур, орчны мэдээллийг ашиглах, аюул болон орчны ноцтой бохирдлоос сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх;

18.1.3. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлуулах;

18.1.4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаарх дүрэм, журмыг батлах;

18.1.5. Хуульд заасан бусад бүрэн эрх.

19 дүгээр зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

19.1. Төрийн захиргааны төв байгууллага ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаарх төрийн бодлого, ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

19.1.2. тусгай хэрэгцээний мэдээний төрөл, үйлчилгээний төлбөрийн хэмжээг батлах;

19.1.3. цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд хяналт тавих;

19.1.4. ажиглалтын станцын хөтөлбөр батлах;

19.1.5. хуульд заасан бусад бүрэн эрх.

20 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх, үүрэг

20.1 Аймаг нийслэл, сум дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах эрх, үүрэгтэй

20.1.1. Улсын сүлжээний ажиглалтын станц, шинжилгээний талбай, хамгаалалтын бүсэд хамаарах газрын асуудлыг хууль, тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, дэмжлэг үзүүлэх, хамгаалалтад хяналт тавих,

20.1.2. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байнгын үйл ажиллагааг дэмжиж, шаардагдах төсвийг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих;

20.1.3. Орон нутгийн онцлог, байгаль ус цаг уур, орчны аюултай үзэгдлээс эрт сэрэмжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхөн олговор олгох;

21 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг

21.1. Аймаг нийслэл, сум дүүргийн Засаг дарга ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах эрх, үүрэгтэй:

21.1.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар хууль тогтоомж, Засгийн газар, бусад эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах;

21.1.2. нутаг дэвсгэрийнхээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний станцын тасралтгүй, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

21.1.3. ус цаг уур, орчны мэдээллээр нутаг дэвсгэрийнхээ хэрэглэгчийг шуурхай хангах, ус цаг уурын гаралтай аюултай үзэгдэл, орчны ноцтой бохирдлоос сэргийлэх ажлыг зохион байгуулах;

21.1.4. нутаг дэвсгэрийнхээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талбай, тоног төхөөрөмжийг хамгаалах арга хэмжээ авах;

21.1.5 нутаг дэвсгэртээ аюулт үзэгдэл, гамшгийн хохирлыг тооцож, хохирлоос урьдчилан сэргийлэх журамд тодотгол хийх, учирсан

хохирлын талаар төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдээлэх;

ДОЛООДУГААР БҮЛЭГ

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ТОГТОЛЦОО

22 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны тогтолцоо

22.1. Монгол Улсын Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны тогтолцоо нь ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “Цаг уур, орчны шинжилгээний ерөнхий газар” гэх/, түүний төв, орон нутаг дахь харьяа байгууллага болох эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, байгаль орчны лаборатори, хэмжил зүйн лаборатори, нисэхийн цаг уурын төв, ус цаг уур, орчны шинжилгээний газар, зайнаас тандах судлал, цаг уурын харилцаа холбоо мэдээллийн төвүүдээс бүрдэнэ.

22.2. Ус цаг уур, орчны шинжилгээний ерөнхий газар нь өөрийн харьяанд Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, судалгаа, инновац, туршилт үйлдвэрлэл, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт болон мэргэжлийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх төв, нэгж байгуулж болно.

22.3. Цаг уур, орчны шинжилгээний ерөнхий газар нь ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албыг мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагаар хангана.

22.4. Цаг уур, орчны шинжилгээний ерөнхий газрын даргыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 174.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газар томилж, чөлөөлнө.

22.5. Энэ хуулийн 22.1-д заасан харьяа байгууллагын зохион байгуулалтын бүтэц, дүрэм, удирдлага /дарга, захирал/-ыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, ажилтныг тухайн байгууллагын удирдлага Төрийн албаны тухай хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.

23 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

23.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах үндсэн чиг үүрэгтэй:

23.1.1. Дэлхийн цаг уурын байгууллагын конвенцийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх, ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

23.1.2. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг удирдан зохион байгуулах;

23.1.3. Ус цаг уур, уур амьсгалын өөрчлөлт болон орчны ажиглалт, хэмжилт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх;

23.1.4. Улсын сүлжээний станцыг байгуулах, татан буулгах, нүүлгэн шилжүүлэх, үйл ажиллагааг зогсоох;

- 23.1.5. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хэмжлийн нэгдмэл байдал, мэдээллийн стандартыг хангах;
- 23.1.6. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг мэдээллээр шуурхай хангах,
- 23.1.7. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг явуулах, нэгдсэн удирдлагаар хангах;
- 23.1.8. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээтэй холбогдсон дүрэм, журам, аргачлал, зааварыг батлах;
- 23.1.9. Ус цаг уур, орчны төлөв байдлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах;
- 23.1.10. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг зохион байгуулах;
- 23.1.11. Уур амьсгалын стандарт нормыг олон улсын аргачлал, шаардлагад нийцүүлэн боловсруулж, батлах;
- 23.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийн эрдэм шинжилгээ, судалгаа, эрсдэлийн үнэлгээг шинжлэх ухааны бусад байгууллагатай хамтран гүйцэтгэх ажлыг зохион байгуулах;
- 23.1.13. Салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 23.1.14. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээллийг цуглуулах, олон улсын солилцоонд гаргах, зохицуулалтаар хангах;
- 23.1.15. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, судалгааны талаар олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 23.1.16. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд ашиглах хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалтын ажлыг гүйцэтгэх;

23.2. Энэ хуулийн 22.1-т заасан харьяа байгууллагын зохион байгуулалтын бүтэц, дүрэм, орон тооны асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

24 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтны нийгмийн баталгаа, үүрэг

24.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтан дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

- 24.1.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албанд тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа мэргэжилийн ажилтанд тав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгоно. Тэтгэмж олгохтой холбоотой журмыг Засгийн газар батална;
- 24.1.2. Ус цаг агаар, орчны онц аюултай үзэгдэлтэй, амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй үед ажилласан ажилтанд ажилласан хугацааны цалин хөлсийг нь гурав дахин нэмэгдүүлж олгох;

24.1.3. Ус цаг агаар, орчны онц аюултай үзэгдэлтэй, амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй үед албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан албан хаагчийн таван жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг сарын үндсэн цалингийн дунджаар тооцож гэр бүлд нь нэг удаа олгох;

24.1.4. Хөдөлмөрийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтанг тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслээр хангах, ажилтанд мөнгөн урамшуулал олгох, түүнийг олгохтой холбоотой журмыг Засгийн газар батална;

24.1.5. Амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтанг гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамруулах;

24.1.6. Ус цаг агаар, орчны онц аюултай үзэгдэлтэй, амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй үед ажилтан албан үүргээ зохих журмын дагуу биелүүлэх явцдаа бусдын эд хөрөнгөд хохирол учруулсан бол тухайн хохирлыг төр хариуцна.

24.1.7. Хуульд заасан бусад.

24.2. Нийгмийн баталгааг хангахад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

24.3. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтан дараах үүрэгтэй:

24.3.1. Ус цаг уур, орчны ажиглалт хэмжилтийг техникийн заавар, хөтөлбөрийн дагуу үнэн зөв, тогтмол, тасралтгүй хийж, үр дүнг шуурхай мэдээлэх;

24.3.2. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалыг чанд сахин мөрдөх;

24.3.3. Мэргэжлийн ёс зүйг чандлан сахих,

24.3.4. Мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх;

24.3.5. Хуульд заасан бусад.

НАЙМДУГААР БҮЛЭГ

УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ

25 дугаар зүйл. Эрдэм шинжилгээ, судалгаа

25.1. Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний бүх үйл ажиллагаа нь эрдэм шинжилгээ, судалгаа, инновац, шинэ технологийн хөгжүүлэлтэнд үндэслэгдэнэ.

25.2. Эрдэм шинжилгээ, судалгааны гол чиглэл нь ус, цаг агаар, уур амьсгал, түүний нөөц, цөлжилт, орчны төлөв байдал, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэл, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн чиглэлээр суурь болон хавсарга судалгаа хийх, хэрэглээний уур амьсгал, уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хувилбар, тоон загварчлал, эрсдэлийн үнэлгээ, богино болон урт хугацааны

урьдчилсан мэдээ гаргах арга зүй боловсруулах, хөгжүүлэх, судалгааны үр дүнг хэрэглээнд нэвтрүүлэхэд чиглэсэн туршилтын үйл ажиллагаа байна.

25.3. Эрдэм шинжилгээ, судалгааг төрийн болон хувийн байгууллага, гадаад, дотоодын их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, олон улсын байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөрөөр хэрэгжүүлж болно.

25.4. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үндсэн санхүүжилт нь улсын төсвөөс бүрдэх бөгөөд шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөр, олон улсын хамтын ажиллагаа, гэрээт болон захиалгат судалгаа, зөвлөх үйлчилгээ, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

25.5. Эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнд бий болсон шинжлэх ухаан, технологийн бүтээгдэхүүн, арга зүй, программ хангамж, загварчлал болон бусад оюуны өмч нь хууль тогтоомжийн дагуу хамгаалагдана.

25.6. Энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиар зохицуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

26 дугаар зүйл. Ус цаг уур, орчны үйлчилгээ

26.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах үйлчилгээг үзүүлнэ:

- 26.1.1. нийтийн хэрэгцээний мэдээгээр хэрэглэгчийг хангах;
- 26.1.2. тусгай хэрэгцээний мэдээгээр хангах;
- 26.1.3. агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх;
- 26.1.4. нисэхийн цаг уурын үйлчилгээ;
- 26.1.5. хэмжилт, ажиглалтын багаж хэрэгслийг баталгаажуулах;
- 26.1.6. орчны чанарын хяналт шинжилгээ үйлчилгээ;
- 26.1.7. уур амьсгалын мэдээллийн үйлчилгээ;
- 26.1.8. хөдөө аж ахуйн цаг уурын үйлчилгээ;
- 26.1.9. Хиймэл дагуулын мэдээний үйлчилгээ

26.2. Энэ хуулийн 26.1.1-д заасан нийтийн хэрэгцээний мэдээгээр хэрэглэгчийг хангах үйлчилгээг үндсэн чиг үүргийн хүрээнд үнэ төлбөргүй үзүүлнэ.

26.3. Энэ хуулийн 26.1.2-26.1.9-д заасан үйлчилгээг хэрэглэгчийн хүсэлтэд үндэслэн төлбөртэй үзүүлнэ. Үйлчилгээний төлбөрийн хэмжээг холбогдох хуулиар эрх олгосон Засгийн газрын гишүүн батална.

26.4. Нисэхийн цаг уурын үйлчилгээг Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц, Олон улсын иргэний нисэхийн байгууллага, Дэлхийн цаг уурын байгууллагын баримт бичиг болон Иргэний нисэхийн тухай хууль, Иргэний нисэхийн дүрэмд нийцсэн эрх бүхий байгууллагаас гэрчилгээжсэн байгууллага үзүүлнэ.

26.5. Нисэхийн цаг уурын үйлчилгээтэй **холбогдох** баримт бичиг, дүрэм журмыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

26.6. Нисэхийн цаг уурын үйлчилгээний төлбөрийн хэмжээг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтооно.

27 дугаар зүйл. Хувийн ус цаг уур, орчны үйлчилгээ

27.1. Монгол Улсад бүртгэлтэй иргэн, хуулийн этгээд нь зөвшөөрөл авч тусгай хэрэгцээний ус цаг уур, орчны мэдээ, мэдээлэл гаргах, хэрэглэгчид хүргэх үйлчилгээ (цаашид “хувийн ус цаг уурын үйлчилгээ” гэх)-г эрхэлж болно.

27.2. Энэ хуулийн 27.1-д заасан энгийн зөвшөөрлийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага таван жилийн хугацаагаар олгоно.

27.3. Зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан нийтлэг шаардлага болон энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасныг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ:

27.3.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээг цуглуулах, боловсруулах, түгээх төлөвлөгөө, төв, орон нутгийн ус цаг уур, орчны шинжилгээний байгууллагаас эх мэдээгээр хангагдах тухай гэрээ;

27.3.2. Ажиглалт, хэмжилт хийх, мэдээлэл боловсруулахад ашиглах техник, тоног төхөөрөмж, программ хангамж нь стандарт, арга зүйн шаардлага хангасан талаар баримт;

27.3.3. Санхүүгийн чадамжтай байх, эх үүсвэр нь хууль ёсны болох тухай баримт;

27.3.4. Мэргэжлийн хүний нөөцтэйг нотлох баримт;

27.4. Зөвшөөрөл эзэмшигч нь ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулсан багаж, тоног төхөөрөмж хэрэглэнэ. Баталгаажуулаагүй багаж, тоног төхөөрөмжийн мэдээ, мэдээллээр **үйлчилгээ мэргэжлийн** үзүүлэхийг хориглоно.

27.5. Зөвшөөрөл эзэмшигч өөрийн боловсруулсан ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийг энэ хуулийн 14.1-д заасан нэгдсэн санд нийлүүлнэ.

27.6. Зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийн хугацаанд шаардлагыг зөрчөөгүй, зөрчил гаргаагүй бол зөвшөөрлийг анх олгосон хугацаагаар сунгана.

АРАВДУГААР БҮЛЭГ

БУСАД

28 дугаар зүйл. Олон улсын хамтын ажиллагаа

28.1. Олон улсын сүлжээнд Цаг уур, орчны шинжилгээний ерөнхий газар нь Монгол улсыг Дэлхийн цаг уурын байгууллагын өмнө төлөөлөх, ус цаг уур, орчны хяналт шинжилгээний нэгдсэн мэдээлэл, зайнаас тандан судлал, цаг уурын харилцаа холбооны үндэсний төвийн үүрэгтэйгээр оролцоно.

28.2 Цаг уур, орчны шинжилгээний ерөнхий газрын дарга нь Монгол улсаас томилогдсон Дэлхийн цаг уурын байгууллагын байнгын төлөөлөгч байна.

28.3. Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ:

28.3.1. Ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээлэл, судалгааны үр дүнг олон улсын байгууллага, гадаад улстай харилцан солилцох;

28.3.2. Бүс нутгийн болон дэлхийн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрт оролцох, хамтран хэрэгжүүлэх;

28.3.3. Олон улсын байгууллага болон гадаад улс оронтой хамтран судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх;

28.3.4. Хүний нөөцийн **чадавхыг** бэхжүүлэх, харилцан солилцох.

29 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

29.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

29.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалтын “шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай;” гэснийг “шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилтын талбай болон ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийх зориулалт бүхий шинжилгээний талбай, түүний хамгаалалтын бүс;” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн “Энгийн зөвшөөрөл” гэсэн хэсэгт “1.17. тусгай хэрэгцээний ус цаг уур, орчны мэдээ, мэдээлэл гаргах, хэрэглэгчид хүргэх үйлчилгээ” гэж, мөн хэсгийн “Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд” гэсэн хэсэгт “Ус цаг уур, орчны шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Дагах төсөл

2026-05-28

Зөвхөн албан хэрэгцээнд

Хувилбар 2

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 21.1.49 дэх заалт нэмсүгэй:

“**21.1.49.** Тусгай хэрэгцээний ус цаг уур, орчны мэдээ, мэдээлэл гаргах, хэрэглэгчид хүргэх үйлчилгээний зөвшөөрөл, гэрчилгээ олгоход 2.000.000 төгрөг, түүний хугацааг сунгахад 1.000.000 төгрөг;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬДНЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулга бүхий 7.20 дугаар зүйл нэмсүгэй:

“7.20 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль зөрчих”

1. Ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийх зориулалт бүхий шинжилгээний талбайд зориулалтын бус багаж, төхөөрөмж, бусад зүйл байрлуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийх зориулалт бүхий шинжилгээний талбайгаас гадагш 100 метр доторх хамгаалалтын бүсэд ажиглалт, хэмжилт хийхэд саад учруулахуйц барилга, өндөрлөг байгууламж барьсан, эсхүл мод тарьсан, эсхүл зам гаргасан, эсхүл тухайн талбайн орчныг төлөөлөх чадварт нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Улсын сүлжээнд хамаарах станцыг зохих шийдвэргүйгээр нүүлгэн шилжүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг шуурхай дамжуулах үүргээ биелүүлээгүй харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Урьдчилан сэргийлэх мэдээг хүлээн авснаас хойш 14 минутын дотор тусгай дуут болон дүрсийн дохиотойгоор нийтэд үнэ төлбөргүйгээр шуурхай мэдээлэх үүргээ биелүүлээгүй харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн байгууллагыг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Ус цаг уур, орчны хуурамч урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг, худал мэдээллийг олон нийтэд түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7. Хүн ам, байгаль орчинд ноцтой нөлөөлөх аюулт үзэгдэл, гамшиг тохиолдсон буюу тохиолдох нөхцөл бүрдсэн тухай мэдээлэх үүргээ биелүүлээгүй хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “7.19 дүгээр зүйлийн 1, 2, 3, 6, 10, 11 дэх хэсэг,” гэсний дараа “7.20 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг,” гэж, мөн хэсгийн 6.37 дахь заалтын “7.17,” гэсний дараа “7.20 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг,” гэж, мөн хэсгийн 6.50 дахь заалтын “6.30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэсний дараа “7.20 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1997 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр Дугаар ... Улаанбаатар хот

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д туссан ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтны нийгмийн баталгааг хангах, шинээр нэмэгдсэн ус цаг уур, орчны үйлчилгээ, судалгаа, эрдэм шинжилгээ, инновац, технологийн хөгжүүлэлтийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн нарийвчилсан тооцоог гаргаж, холбогдох байгууллагын төсөв, урсгал зардлыг одоогийн батлагдсан түвшнээс **хоёр дахинаас доошгүй хэмжээгээр нэмэгдүүлэх** асуудлыг Монгол Улсын жил бүрийн улсын төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтны нийгмийн баталгаанд шаардагдах **14.0 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт**, судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн санхүүжилт, шинээр нэмэгдсэн үйлчилгээний зохион байгуулалт, мэдээллийн сан, техник, тоног төхөөрөмж, хүний нөөц, сургалт, мэргэшүүлэх арга хэмжээний зардлыг тус тус тооцон, хэрэгжилтийн явц, санхүүжилтийн үр дүнг жил бүр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д туссан ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтны нийгмийн баталгааг хангах, мөн хуулиар шинээр болон өргөжин нэмэгдсэн ус цаг уур, орчны үйлчилгээ, судалгаа, эрдэм шинжилгээ, инновац, технологийн хөгжүүлэлт, мэдээллийн сан, техник, тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн хэрэгцээ, эх үүсвэрийн нарийвчилсан тооцоог гаргаж, холбогдох байгууллагын төсөв, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг үе шаттай нэмэгдүүлэх саналыг Монгол Улсын жил бүрийн улсын төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /...../-т даалгасугай.
2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтны нийгмийн баталгаанд шаардагдах санхүүжилт, түүний дотор урьдчилсан тооцоогоор 14.0 орчим тэрбум төгрөгийн хэрэгцээ, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны үндсэн санхүүжилт, шинээр нэмэгдсэн үйлчилгээний зохион байгуулалт, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл, хүний нөөцийг бэлтгэх, сургах, мэргэшүүлэх арга хэмжээний зардлыг тус тус тооцож, хэрэгжилтийн явц, санхүүжилтийн үр дүнг жил бүр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /...../-т даалгасугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /...../-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
.....

УИХ-ЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

УИХ-ын тогтоолын төслийг боловсруулах болсон шалтгаан нь Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан уг хуулийг хэрэгжүүлэх зохион байгуулалт, шилжилтийн арга хэмжээ, холбогдох байгууллагуудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгох шаардлага үүссэнтэй холбоотой юм.

Тухайлбал, хуулийн төсөлд “үндэсний цаг уурын алба”, “цаг уурын албаны тогтолцоо” зэрэг нэр томьёо, байгууллагын бүтэц, улсын сүлжээ, мэдээлэл боловсруулах, түгээх, сэрэмжлүүлэх чиг үүргийг шинэчлэн тодорхойлж байгаа тул эдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг УИХ-ын тогтоолоор баталгаажуулах шаардлагатай байна.

Илүү товч хувилбар:

УИХ-ын тогтоолын төслийг боловсруулах болсон үндсэн шалтгаан нь хуулийн шинэчилсэн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохион байгуулалт, шилжилтийн арга хэмжээ, байгууллагуудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгох хэрэгцээ шаардлага үүссэнтэй холбоотой юм.

Илүү хүчтэй, үндэслэлтэй хувилбар:

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын эрх зүйн зохицуулалтыг шинэчлэхтэй холбогдуулан үндэсний цаг уурын албаны эрх зүйн байдал, цаг уурын албаны тогтолцоо, улсын сүлжээ, мэдээлэл солилцоо, гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх үйл ажиллагааг нэгдсэн бодлого, зохион байгуулалтаар хэрэгжүүлэх шаардлага бий болсон. Иймд хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ, байгууллагуудын уялдаа холбоо, шилжилтийн зохицуулалтыг тодорхойлох зорилгоор УИХ-ын тогтоолын төслийг боловсруулж байна.

УИХ-ын тогтоолын төслийг боловсруулах болсон шалтгаан нь Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан салбарын эрх зүйн зохицуулалт, байгууллагын чиг үүрэг, улсын сүлжээ, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, хэмжилт шинжилгээний чанар, стандарт, гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх үйл ажиллагаа зэрэг шинэ болон өөрчлөн найруулсан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ, шилжилтийн зохицуулалт, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог тодорхой болгох хэрэгцээ шаардлага үүссэнтэй холбоотой юм.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын мэдээллийн сан, цахим систем, инновац, хиймэл оюун ухаанд суурилсан технологи, судалгаа шинжилгээ, үйлчилгээний хүртээмж, хүний нөөцийн нийгмийн баталгаа болон байгууллагын чадавхыг бэхжүүлэхтэй холбоотой шинэ зохицуулалтууд тусгагдсан. Үүнтэй холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангахад шаардагдах зохион байгуулалт, хүний нөөц, техник, технологи, санхүүжилт, урсгал зардал болон

шилжилтийн арга хэмжээг тодорхойлох шаардлага бий болсон тул Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллага нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр тасралтгүй хангах, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэрэмжлүүлэх, нийгэм, эдийн засгийн салбарын хэвийн үйл ажиллагааг дэмжих онцгой чиг үүрэг бүхий байгууллага юм. Иймээс тус байгууллагын үйл ажиллагаа нь ажлын ердийн цагийн горимоор хязгаарлагдахгүй, хоногийн 24 цаг, долоо хоногийн 7 өдөр тасралтгүй, байнгын бэлэн байдлаар ажилладаг.

Гэвч өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн орон тооны 10 хувийн цомхотголын улмаас ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагын хүний нөөцийн хүрэлцээ буурч, ялангуяа ээлжийн зохион байгуулалтаар ажилладаг нэгжүүдэд ажлын ачаалал эрс нэмэгдсэн байна. Тухайлбал, 24 цагийн тасралтгүй ажиллагаатай нэгжид 5 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэйгээр ээлжийн ажлыг зохион байгуулах нь ажилтан ээлжийн амралтаа эдлэх, өвчтэй, чөлөөтэй байх, сургалт, мэргэшүүлэх арга хэмжээнд хамрагдах, илүү цагийн ажлыг нөхөн амрах зэрэг хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан баталгааг бүрэн хангахад хүндрэл үүсгэж байна.

Энэ нөхцөл байдал нь ажилтны хөдөлмөрлөх эрх, амрах эрх, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг хангахтай холбоотой эрсдэлийг бий болгож, байгууллагын тасралтгүй, найдвартай ажиллагаа, мэдээ, мэдээллийн шуурхай байдал, чанар, аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээллийн тогтвортой байдлыг алдагдуулах сөрөг үр дагавартай юм.

Иймд Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан тус хуульд шинээр болон өргөжин нэмэгдсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын тасралтгүй ажиллагааг хангах, хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн ээлжийн зохион байгуулалтыг бүрдүүлэх, ажилтны нийгмийн баталгаа, хөдөлмөрийн аюулгүй, зохистой нөхцөлийг хангах зорилгоор өмнө нь цомхотгосон орон тоог үе шаттай нөхөн нэмэгдүүлэх, шаардлагатай хүний нөөц, цалин хөлс, сургалт, мэргэшүүлэх арга хэмжээний санхүүжилтийг улсын төсөвт тусган шийдвэрлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагын 24 цагийн тасралтгүй ажиллагаа, ээлжийн ажлын хэвийн зохион байгуулалт, ажилтны хөдөлмөрлөх, амрах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг хангах зорилгоор өмнө нь хэрэгжүүлсэн орон тооны цомхотголын улмаас үүссэн хүний нөөцийн дутагдлыг нөхөх, шинээр болон өргөжин нэмэгдсэн чиг үүрэгт шаардагдах орон тоо, цалин хөлс, сургалт, мэргэшүүлэх арга хэмжээний санхүүжилтийг тооцож, холбогдох байгууллагын төсөвт үе шаттай тусган шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /...../-т даалгасугай:
 - 1.1. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, ажиглалтын станц, шинжилгээний талбай, лаборатори, мэдээлэл дамжуулах болон боловсруулах дэд бүтцийг үе шаттайгаар шинэчлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх;
 - 1.2. цаг агаар, ус, орчны аюултай болон онц аюултай үзэгдлээс урьдчилан сэрэмжлүүлэх, нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ, мэдээллийн үйлчилгээний хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэхэд шаардагдах техник, технологи, программ хангамж, хүний нөөцийн хэрэгцээний нарийвчилсан тооцоог гаргах;
 - 1.3. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтны нийгмийн баталгааг хангах, эрсдэлтэй болон тасралтгүй ажиллагаатай ажлын байрны онцлогт нийцсэн цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, даатгал, хамгаалах хэрэгслийн санхүүжилтийг улсын төсөвт үе шаттайгаар тусган шийдвэрлүүлэх;
 - 1.4. хуулиар шинээр болон өргөжүүлэн зохицуулсан судалгаа, эрдэм шинжилгээ, инновац, туршилт үйлдвэрлэл, уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээ, мэдээллийн сан, цахим систем, кибер аюулгүй байдал, хувийн ус цаг уур, орчны үйлчилгээний зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зохион байгуулалт, хүний нөөц, санхүүжилтийн тооцоог гаргаж, холбогдох төсөвт тусгах;
 - 1.5. ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын хүний нөөцийн дутагдлыг бууруулах, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, орон нутагт тогтвортой ажиллуулах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;
 - 1.6. энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журам, аргачлал, стандарт, техникийн зааврыг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш тогтоосон хугацаанд баталж, мөрдүүлэх;
 - 1.7. хууль хэрэгжүүлэхтэй холбогдон шаардагдах санхүүжилт, хөрөнгө оруулалт, урсгал зардлыг Монгол Улсын жил бүрийн улсын төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлэх.

2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан арга хэмжээний хэрэгжилт, шаардагдах санхүүжилтийн тооцоо, улсын төсөвт тусгасан байдал, хүний нөөц, техник, технологийн шинэчлэл, мэдээллийн сан, урьдчилан сэрэмжлүүлэх тогтолцооны хэрэгжилтийн явцыг жил бүр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /...../-т даалгасугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /...../-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

.....